



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2017 оны 6 дугаар сар


Ерөнхий тойм: Энэ оны эхний 6 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 36.4%-иар буюу 1344.4 сая ам.доллараар өсч 5,036 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 42%-иар буюу 912.9 сая ам.доллараар, импорт 28.8%-иар буюу 431.5 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлжээ. Тайлант хугацаанд экспортын дүн импортын дүнгээс 1,175 сая ам.доллараар давсанаар гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 481.4 сая ам.доллараар өссөн байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 6 сар			Өөрчлөлт			
	2014	2015	2016	2015/2014		2016/2015		2015	2016	2017	2016/2015		2017/2016	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	11,011	8,467	8,274	(2,544)	-23.1%	(192)	-2.3%	4,209	3,692	5,036	(517)	-12.3%	1344.4	36.4%
Экспорт	5,774	4,669	4,916	(1,105)	-19.1%	247	5.3%	2,370	2,193	3,105.8	(177)	-7.5%	912.9	42%
Импорт	5,237	3,798	3,358	(1,439)	-27.5%	(439)	-11.6%	1,839	1,499	1,930.6	(340)	-18.5%	431.5	28.8%
Тэнцэл	538	872	1,558	334		686	78.7%	531	694	1,175	162	30.5%	481.4	69.4%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2017 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 1,239 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 439.6 сая ам.доллараар өссөн байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /6 сарын гулсах дундаж/



Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 67.4% буюу 3392.4 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 11.1% буюу 559 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 48.6%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 43.5%-иар тус тус өссөн байна.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /6 сарын гулсах дундаж/



Хүснэгт 2. Худалдааны нөхцөлийн индекс /2012 оны 12 сар суурьтай/

Үнийн индексийн төрөл*	2016.06 сар	2017.05 сар	2017.06 сар	Жил Δ	Сар Δ
Экспорт	0.72	1.03	0.98	36%	-5%
Зэсийн баяжмал	0.32	0.40	0.38	19%	-5%
Чулуун нүүрс	0.39	0.70	0.67	72%	-4%
Ямааны угаасан ноолуур	0.34	0.43	0.39	15%	-9%
Импорт	0.56	0.59	0.57	1%	-4%
Хэрэглээний бараа	0.77	0.74	0.76	-1%	2%
Хөрөнгө оруулалтын бараа	0.50	0.53	0.45	-10%	-15%
Нефтийн бүтээгдэхүүн	0.47	0.55	0.53	15%	-3%
Худалдааны нөхцөл	1.29	1.75	1.73	34%	-1%

* Индексийн өөрчлөлтөд голлох хувь нэмэр оруулсан бараагаар задлав.

Гадаад худалдааны нөхцөлийн индекс тайлант хугацааны эцэст өмнөх оны мөн үеэс 34%-иар өссөн бол өмнөх сараас 1%-иар буурч 1.73-д хүрлээ. Тайлант сард хөрөнгө оруулалт, нефтийн импортын үнэ буурсан, нүүрс, зэс болон ямааны угаасан ноолуурын экспортын үнэ буурснаас голлон шалтгаалж худалдааны нөхцөл өмнөх сараас бага зэрэг муудсан байна.

Экспорт 2017 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 41.6%-иар буюу 912.9 сая ам.доллараар өсөв. Уул уурхайн түүхий эдийн экспортын өсөлт нь нийт экспортыг 38.7 нэгж хувиар, уул уурхайгаас бусад төрлийн экспорт нь нийт экспортыг 2.9 нэгж хувиар өсөхөд нөлөөлжээ. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 2 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2015			2016			2017			Δ (2016/2015)			Δ (2017/2016)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
1. Уул уурхай		2,060	87%	1,880	86%		2,729	88%		(180)	-9%	-8%	849	45%	38.7%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	664	1,147	48%	821	920	42%	733	765	25%	(227)	-20%	-10%	(156)	-17%	-7%
1.2. Чулуун нүүрс	6,856	309	13%	9,678	295	13%	18,957	1,278	41%	(13)	-4%	-1%	982	333%	45%
1.3. Боловсруулаагүй нефть	3,771	197	8%	4,179	160	7%	3,720	182	6%	(37)	-19%	-2%	22	14%	1%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	2,272	115	5%	2,587	98	4%	2,689	159	5%	(16)	-14%	-1%	60	61%	3%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	4,014	158	7%	7,074	280	13%	4,471	180	6%	122	77%	5%	(100)	-36%	-5%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	56	71	3%	68	72	3%	58	86	3%	1	2%	0%	14	19%	1%
1.7. Жонш, лейцит, нефелинт	138	32	1%	119	27	1%	143	34	1%	(4)	-14%	0%	7	25%	0%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	2	18	1%	3	12	1%	3	16	1%	(6)	-34%	0%	4	37%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	1	5	0%	1	4	0%	0	2	0%	(1)	-23%	0%	(2)	-61%	0%
1.10. Мөнгө /тонн/	27	7	0%	22	9	0%	0	0	0%	2	0%	0%	(9)	-97%	0%
1.11. Бусад	46	1	0%	46	1	0%	200	26	1%	(0)	-29%	0%	25	1%	1%
2. Мал аж ахуй		187	8%	190	9%		226	7%		4	2%	0%	36	19%	1.7%
2.1. Амьд мал, малын мах	2	6	0%	2	5	0%	6	10	0%	(1)	-13%	0%	5	103%	0%
2.2. Арьс, шир	154	18	1%	103	17	1%	167	14	0%	(1)	-6%	0%	(2)	-14%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	5	0%	0	4	0%	0	4	0%	(1)	-25%	0%	(0)	-5%	0%
2.4. Ноолуур	4	150	6%	5	156	7%	6	191	6%	6	4%	0%	34	22%	2%
2.5. Ноос, бусад үс, хялгас	5	8	0%	5	8	0%	4	6	0%	0	1%	0%	(2)	-24%	0%
2.6. Бусад	0	0	0%	0	0	0%	1	1	0%	0	265%	0%	1	229%	0%
3. Газар тариалан		21	1%	11	1%		6	0%		(10)	-46%	0%	(6)	-51%	-0.3%
4. Аж үйлдвэрлэл		101	4%	111	5%		145	5%		10	10%	0%	34	30%	1.5%
4.1. Хүнс	2	15	1%	3	16	1%	12	53	2%	1	10%	0%	37	228%	2%
4.2. Ноолууран эдлэл	0	7	0%	0	7	0%	0	8	0%	(0)	-6%	0%	1	9%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	0	3	0%	1	6	0%	1	5	0%	3	76%	0%	(0)	-7%	0%
4.4. Уул уурхай	22	40	2%	12	33	2%	18	53	2%	(7)	-17%	0%	19	57%	1%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	1	0%	0	0	0%	0	1	0%	(1)	-52%	0%	0	6%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	32	1%	1	45	2%	1	23	1%	13	40%	1%	(22)	-49%	-1%
4.7. Бусад	108	3	0%	103	4	0%	230	3	0%	1	31%	0%	(1)	-19%	0%
5. Бусад		1	0%	1	0%		0	0%		(1)	-64%	0%	(0)	-20%	0.0%
Нийт дүн		2,370		2,193			3,106			(177)	-7%		912.9	41.6%	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 4. Экспортын өөрчлөлт, 2017 он

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	419.3	49%	429.7	51%	848.9	45%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(92.2)	59%	(63.4)	41%	(155.6)	-17%
1.2. Чулуун нүүрс	625.4	64%	357.1	36%	982.5	333%
1.3. Боловсруулаагүй нефть	(22.5)	-101%	44.7	201%	22.2	14%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	6.0	10%	54.5	90%	60.5	61%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	(105.0)	105%	5.1	-5%	(99.9)	-36%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	(15.2)	-108%	29.3	208%	14.0	19%
1.7. Жонш, лейцит, нефелинт	5.6	81%	1.3	19%	6.9	25%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	(0.1)	-1%	4.5	101%	4.5	37%
1.11. Бусад	20.0	80%	5.0	20%	25.0	0%
2. Мал аж ахуй	31.0	86%	5.2	14%	36.2	19%
2.2. Арьс, шир	5.5	-235%	(7.8)	335%	(2.3)	-14%
2.4. Ноолуур	21.0	61%	13.5	39%	34.5	22%
3. Газар тариалан	(1.3)	22%	(4.6)	78%	(5.8)	-51%
4. Аж үйлдвэрлэл	60.7	180%	(27.1)	-80%	33.7	30%
5. Бусад	(0.0)	33%	(0.1)	67%	(0.1)	-20%
Нийт дүн	510	56%	403	44%	913	42%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2017 оны эхний 6 сарын гүйцэтгэл нь экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 510 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 403 сая ам.доллараар өссөн байна. Уул уурхайн түүхий эдийн экспорт нүүрсний экспортын биет хэмжээ, үнэ өссөнөөс шалтгаалж 848.9 сая ам.доллараар өссөн байна. Харин мал аж, ахуйн түүхий эдийн экспорт үнэ, тоо хэмжээний аль аль нь нэмэгдсэнээс шалтгаалж 36.2 сая ам.доллараар өссөн байна. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын үнэ буурсан хэдий ч биет хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалж 33.7 сая ам.доллараар өссөн байна.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2017 оны 6 дугаар сард 1,260 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.3%-иар буурсан, өнгөрсөн сараас 2.1%-иар өссөн. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 5,719, 57.5 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 23.2%-иар, төмрийн хүдэр 10.3%-иар өссөн бол өнгөрсөн сартай харьцуулахад харгалзан 3% өссөн, 8.7%-иар буурсан байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 6 дугаар сард 67 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 126.9%-иар өссөн бол өмнөх сараас 2.9%-иар буурсан байна.

Импорт 2017 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 28.8%-иар буюу 431.5 сая ам.доллараар өссөн. Импортын өсөлтийг ерөнхий ангилалаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 15 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 11 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 4 нэгж хувийг тус тус тайлбарлаж байна. Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 5 нэгж хувиар буурсан бол нефтийн бүтээгдэхүүний жин 5 нэгж хувиар өсчээ.

Хүснэгт 5. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2015			2016			2017			Δ (2016/2015)			Δ (2017/2016)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
Хэрэглээний бүтээгдэхүүн		548	30%		540	36%		602	31%	(7)	-1%	0%	62	11%	4%
Түргэн эдэлгээтэй	362	304	17%	365	280	19%	424	328	17%	(24)	-8%	-1%	48	17%	3%
Хүнс	183	209	11%	189	192	13%	179	228	12%	(17)	-8%	-1%	36	19%	2%
Эм, тариа	1	35	2%	1	42	3%	1	42	2%	7	19%	0%	(0)	-1%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	178	59	3%	175	45	3%	244	58	3%	(14)	-23%	-1%	13	28%	1%
Удаан эдэлгээтэй	97	244	13%	66	261	17%	107	274	14%	17	7%	1%	14	5%	1%
Гутал, хувцас, цүнх	21	22	1%	25	23	2%	31	27	1%	0	2%	0%	4	16%	0%
Гэр ахуйн цах хэрэгсэл ба тавилга	49	50	3%	11	51	3%	40	41	2%	1	1%	0%	(10)	-19%	-1%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	1	138	7%	0	156	10%	1	174	9%	18	13%	1%	17	11%	1%
Бусад удаан эдэлгээтэй бараа	26	34	2%	30	31	2%	35	33	2%	(3)	-8%	0%	2	7%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн		685	37%		503	34%		722	37%	(182)	-27%	-10%	220	44%	15%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	9	360	20%	7	283	19%	11	472	24%	(77)	-21%	-4%	189	67%	13%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	1	63	3%	0	72	5%	0	122	6%	9	14%	0%	50	70%	3%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	9	297	16%	7	211	14%	11	350	18%	(86)	-29%	-5%	139	66%	9%
Барилгын материал	814	240	13%	358	131	9%	268	172	9%	(109)	-45%	-6%	41	31%	3%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	34	84	5%	22	88	6%	32	78	4%	4	5%	0%	(10)	-11%	-1%
Аж үйлдвэрлэлийн орц		259	14%		261	17%		248	13%	2	1%	0%	(13)	-5%	-1%
Хүнсний орц	27	16	1%	155	41	3%	20	9	0%	25	155%	1%	(31)	-77%	-2%
Химийн бүтээгдэхүүн	72	50	3%	62	41	3%	84	49	3%	(9)	-17%	0%	8	20%	1%
Даавуу, утас, арьс, савжин эдлэл	9	8	0%	10	9	1%	20	11	1%	1	11%	0%	2	21%	0%
Цахилгаан эрчим хүч	1	65	4%	1	61	4%	1	63	3%	(4)	-6%	0%	2	3%	0%
Металлын хүдэр, баямал болон хаягдал	0	1	0%	1	1	0%	1	0	0%	(0)	-8%	0%	(0)	-59%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтат	420	120	7%	364	108	7%	425	115	6%	(12)	-10%	-1%	6	6%	0%
Нефтийн бүтээгдэхүүн		515	31%		419	13%		612	18%	(138)	-42%	-7%	161	83%	11%
Дизель түнш	289	176	10%	211	86	6%	369	197	10%	(90)	-51%	-5%	111	129%	7%
АИ-92, АИ-95	170	110	6%	152	72	5%	168	101	5%	(38)	-35%	-2%	29	41%	2%
А-80 болон бусад	56	45	2%	56	36	2%	76	57	3%	(10)	-21%	-1%	21	59%	1%
Бусад	11	16	1%	3	2	0%	51	4	0%	(14)	-1%	-1%	2	2%	0%
Нийт дүн		1,839		1,499		1,931		1,931		(340)	-18.5%		431.5	28.8%	


%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 6. Импортын өөрчлөлт, 2017 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	96.1	155%	(34.2)	-55%	61.9	11%
Түргэн эдэлгээтэй	23.5	49%	24.7	51%	48.2	17%
Удаан эдэлгээтэй	72.7	528%	(58.9)	-428%	13.8	5%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	180.5	82%	39.2	18%	219.7	44%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	169.9	90%	18.9	10%	188.8	67%
Барилгын материал	17.4	42%	23.6	58%	40.9	31%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	(6.8)	67%	(3.3)	33%	(10.1)	-11%
Аж үйлдвэрлэлийн орц	(5.2)		(8.0)		(13.2)	-5%
Нефтийн бүтээгдэхүүн	108.6	67%	52.7	33%	161.3	83%
Дизель түнш	84.0	76%	26.8	24%	110.8	129%
АИ-92, АИ-95	9.4	32%	19.9	68%	29.3	41%
А-80 болон бусад	15.2	71%	6.1	29%	21.3	59%
Бусад	3.4	189%	(1.6)	-89%	1.8	0%
Нийт дүн	383.4	89%	48.1	11%	431	29%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд баатдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /5 сарын гулсах дундаж/



2017 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр импорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалаж 383.4 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 48.1 сая ам.доллараар тус тус өсчээ. Хэрэглээний бүтээгдэхүүний импорт нь тоо хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалж 61.9 сая ам.доллараар өсчээ. Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 44%-иар өссөн нь уг бүлгийн импортын тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

Харин нефтийн бүтээгдэхүүний импортын хэмжээ 83%-иар өсчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2017 оны 6 дугаар сарын байдлаар тонн тутамд 551 ам.долларт хүрсэн байна.